



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/255

Есөнбулаг

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсгүүд, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” А/254 дүгээр тушаалаар баталсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Есөнбулаг сумын Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн лабораторийн барилгын засварын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга	Ц.Бат-Орших	(Алтай тохижилт үйлчилгээний газрын дарга)
Гишүүн:	А.Бямбадорж	(Иргэний төлөөлөл)
		(тохиролцсоноор)
Нарийн бичиг:	Б.Эрхбаяр	(Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн)

2. Төндөрийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Ц.Бат-Орших)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ